

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ДОТООДЫН ЦЭРГИЙН ТУХАЙ НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын дотоодын цэргийн Цаашид "Дотоодын цэрэг" гэх/ тогтолцоо, чиг үүрэг, бүрэн эрх, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Дотоодын цэргийн тухай хууль тогтоомж

2.1.Дотоодын цэргийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль,Цэргийн албаны тухай хууль, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Цагдаагийн албаны тухай хууль, энэ хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоос бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

2.3.Дотоодын цэргийн алба хаагчийн албаны үүрэг гүйцэтгэхтэй холбогдсон энэ хуулиар зохицуулаагүй бусад харилцааг дотоодын цэргийн алба-ажиллагааны дүрэм болон цэргийн нийтлэг дүрмээр зохицуулна.

3 дугаар зүйл.Дотоодын цэргийн үйл ажиллагааны зарчим

3.1.Дотоодын цэрэг нь үйл ажиллагаандаа хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, нууцыг чанд хадгалах, нэгдмэл төвлөрсөн удирдлагатай байх, захирах, захирагдах, хамгаалалтыг уян хатан, шуурхай тасралтгүй зохион байгуулах зарчмыг баримтална.

4 дүгээр зүйл.Нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“улсын онц чухал объект” гэж Монгол Улсын Засгийн газраас /цаашид “Засгийн газар” гэх/ тогтоосон улс орны нийгэм, эдийн засгийн онцгой ач холбогдол бүхий үйлдвэр, албан газар, байгууллага, барилга байгууламжийг;

4.1.2.“объектын хамгаалалт” гэж улсын онц чухал объектын хэвийн ажиллагааг хангах, халдлагаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хамгаалж байгаа объектод нэвтрэх хүн, эд зүйл, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, хамгаалалтын бүсэд тогтоосон дэглэм, журмыг сахиулах цогц үйл ажиллагааг;

4.1.3.“дотоодын цэргийн алба-ажиллагаа” гэж улсын онц чухал объектыг хамгаалах, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргийг таслан зогсоход оролцох болон хуулиар тогтоосон бусад үүргийг хэрэгжүүлэхээр явуулж байгаа цогцолбор ажиллагааг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ДОТООДЫН ЦЭРГИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, УДИРДЛАГА

5 дугаар зүйл.Дотоодын цэргийг удирдах талаар Засгийн газрын бүрэн эрх

5.1.Засгийн газар нь дотоодын цэргийг удирдах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.1.дотоодын цэргийн анги байгуулах, татан буулгах, байршлыг тогтоох;

5.1.2.дотоодын цэргийн алба-ажиллагааны дүрмийг батлах;

5.1.3.дотоодын цэргийн алба хаагчид олгох албаны нэмэгдлийг хууль тогтоомжийн дагуу тогтоох;

5.1.4.улсын онц чухал объектын жагсаалтыг батлах;

5.1.5.дотоодын цэрэгт алба хаах хугацаат болон гэрээт цэргийн алба хаагчийн тоо, нийт бие бүрэлдэхүүний орон тооны дээд хязгаарыг тогтоох;

5.1.6.дотоодын цэргийн алба хаагчийг хуульд заасан эдийн засаг, нийгмийн баталгаагаар хангах;

5.1.7.хууль тогтоомжид заасан бусад.

6 дугаар зүйл.Дотоодын цэргийг удирдах талаар дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх

6.1.Дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь дотоодын цэргийг удирдах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1.дотоодын цэргийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэх, үйл ажиллагааны тайланг сонсох, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

6.1.2.дотоодын цэрэг энэ хуулийн 10.1-д заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд хэрэглэх тусгай хэрэгсэл, галт зэвсэг, тусгай техникийн төрөл, тэдгээрийг хэрэглэх зааврыг дотоодын цэргийн командлагчийн саналыг үндэслэн Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн батлах;

6.1.3.дотоодын цэргийн командлагчийн саналыг үндэслэн дотоодын цэргийн анги байгуулах, байршлыг өөрчлөх, татан буулгах саналыг Засгийн газарт танилцуулах;

6.1.4.дотоодын цэргийг энэ хуулийн 12.1.2, 12.1.3-т заасан арга хэмжээнд татан оролцуулах тухай дотоодын цэргийн командлагчийн саналыг хүлээн авч шийдвэрлэх.

7 дугаар зүйл.Дотоодын цэргийн бүтэц, удирдлага

7.1.Дотоодын цэрэг нь дотоодын цэргийн штаб /цаашид “штаб” гэх/, анги, салбараас бүрдэнэ.

7.2.Цагдаагийн төв байгууллагын дарга нь дотоодын цэргийн командлагч байна.

7.3.Дотоодын цэргийн анги, салбарыг эрх бүхий дээд шатны байгууллагаас томилсон захирагч удирдана.

8 дугаар зүйл.Дотоодын цэргийн командлагчийн бүрэн эрх

8.1.Дотоодын цэргийн командлагч дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1.дотоодын цэргийн үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулж удирдах;

8.1.2.дотоодын цэргийн анги, салбарын чиг үүргийг тогтоож, үйл ажиллагааны удирдамж, төлөвлөгөө, журмыг батлах;

8.1.3.цагдаагийн байгууллагатай харилцан ажиллах удирдамж, төлөвлөгөөг батлах;

8.1.4.цэргийн нийтлэг дүрмүүдээр зохицуулахаас бусад дотоодын цэргийн үйл ажиллагаанд дагаж мөрдөх дүрэм, журам, зааврыг хуульд тогтоомжид нийцүүлэн баталж мөрдүүлэх, биелэлтийг хангуулах;

8.1.5.улсын онц чухал объектын хамгаалалтын үйл ажиллагааны стандарт, аюулгүйн арга хэмжээний зааврыг батлах;

8.1.6.дотоодын цэргийг бие бүрэлдэхүүн, зэвсэг, техник, материал хэрэгслээр хангах ажлыг зохион байгуулж удирдах;

8.1.7.дотоодын цэргийг бүхэлд нь, эсхүл тодорхой анги, салбарыг өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлэх, өндөржүүлсэн бэлэн байдлыг цуцлах шийдвэр гаргах;

8.1.8.цэрэг татах, халах талаар төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, хууль тогтоомжид заасан үндэслэлээр дотоодын цэргийн алба хаагчийг цэргийн жинхэнэ албанаас чөлөөлөх, халах, бэлтгэл үүрэгтнийг чөлөөнд гаргаж бүртгэлээс хасах;

8.1.9.цэргийн жинхэнэ алба хаагчийг офицерын албанд томилох, чөлөөлөх, халах;

8.1.10.дотоодын цэргийн хүний нөөцийг сургаж бэлтгэх, нөхөн хангах ажлыг зохион байгуулах;

8.1.11.цэргийн нийтлэг дүрэмд заасан бусад.

9 дүгээр зүйл.Дотоодын цэргийн штаб

9.1.Штаб нь дотоодын цэргийг удирдах мэргэжлийн байгууллага мөн.

9.2.Штаб нь дотоодын цэргийн командлагчийн удирдлагад ажиллана.

9.3.Штабын даргыг дотоодын цэргийн командлагч томилно.

9.4.Штабын дарга дотоодын цэргийн хуульд заасан чиг үүрэгтэй холбогдсон асуудлаар бусад байгууллагатай харилцан өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулж, цэргийн жинхэнэ алба хаагчийг ахлагчийн албанд томилж, чөлөөлж, хална.

9.5.Дотоодын цэрэг нь тогтоосон журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ДОТООДЫН ЦЭРГИЙН ЧИГ ҮҮРЭГ

10 дугаар зүйл.Дотоодын цэргийн үндсэн чиг үүрэг

10.1.Дотоодын цэрэг нь дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

10.1.1.улсын онц чухал объектыг хамгаалах;

10.1.2.нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргийг таслан зогсооход дэмжлэг үзүүлэх;

10.1.3.байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон, техникийн холбогдолтой осол, гал түймэр, хүн, малын гоц халдварт өвчин гарсан үед аврах ажил болон хорио цээрийн дэглэмийг сахиулахад оролцох;

10.1.4.шаардлагатай үед зарим объектыг түр хугацаагаар хамгаалах, зорчигч, ачаа тээшийг тээврийн замд харгалзан хүргэх;

10.1.5.террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох;

10.1.5.хуулиар тогтоосон бусад чиг үүрэг.

10.2.Дотоодын цэргийн албаны үйл ажиллагааг дотоодын цэргийн алба-ажиллагааны дүрмээр зохицуулна.

10.3.Дотоодын цэрэг нь байнгын болон өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах бөгөөд ердийн нөхцөлд байнгын бэлэн байдалд байна.

11 дүгээр зүйл.Улсын онц чухал объектыг хамгаалах

11.1.Дотоодын цэргийн байгууллага Засгийн газраас тогтоосон улсын онц чухал объектыг хамгаалах зорилгоор дараахь үүргийг гүйцэтгэнэ:

11.1.1.улсын онц чухал объектыг хамгаалах, тэдгээрт нэвтрүүлэх хүн, тээврийн хэрэгсэл, ачаа тээш, эд зүйлийг шалгах, бүртгэх;

11.1.2.эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас тогтоосон дүрэм, шалган нэвтрүүлэх журмыг хэрэгжүүлэх, биелэлтэд хяналт тавих;

11.1.3.улсын онц чухал объектод гарсан байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул, техникийн холбогдолтой осол, гал түймэрийн хор уршигийг арилгахад туслалцаа үзүүлэх;

11.1.4.хамгаалалтад байгаа объектод хууль бусаар нэвтэрсэн этгээдийг мөрдөн хөөх, саатуулах, цагдаагийн байгууллагад хүргэх;

11.1.5.хамгаалалтад авсан объектод хорлон сүйтгэх ажиллагаа явуулах, террор ажиллагаа үйлдэхээс урьдчилан сэргийлэх;

11.2.Хамгаалж байгаа объектын хэвийн үйл ажиллагаа алдагдсан, зөрчил илэрсэн үед объектын захиргаа, нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага болон бусад анги, салбартай мэдээлэл солилцох, тэдгээрийн хүч хэрэгслийг ашиглах, объектийн онцлогт тохирсон шалган нэвтрүүлэх журмыг анги, салбарын захирагч холбогдох байгууллагатай зөвшилцөн тогтооно.

12 дугаар зүйл.Дотоодын цэрэг нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргийг таслан зогсооход дэмжлэг үзүүлэх

12.1.Цагдаагийн байгууллагаас хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүч хэрэгсэл хүрэлцэхгүй тохиолдолд цагдаагийн байгууллагад дэмжлэг үзүүлэх зорилгоор дотоодын цэрэг дараахь үүргийг гүйцэтгэнэ:

12.1.1.баяр наадам, жагсаал, цуглаан зэрэг нийтийг хамарсан арга хэмжээний үед нийтийн хэв журмыг сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангахад оролцох;

12.1.2.гудамж, талбай зэрэг олон нийтийн газарт үүссэн нийтийг хамарсан эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, иргэдийн болон төрийн байгууллагын аюулгүй байдал, өмч хөрөнгийг хамгаалахад оролцох;

12.1.3.гяндан, чанга, онцгой дэглэмтэй хорих анги, цагдан хорих байранд үймээн гарсан үед дэг журам тогтооход оролцох;

12.1.4.оргон нуугдсан гэмт этгээдийг баривчлах, сураггүй алга болсон этгээдийг эрж олох талаар цагдаагийн болон хорих байгууллагаас явуулж байгаа нэгдсэн арга хэмжээнд оролцох;

12.1.5.шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх;

12.1.6.гэрч, хохирогчийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх;

12.1.7.сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтныг хуяглан хүргэх ажиллагаанд туслах

12.1.8.шаардлагатай тохиолдолд хууль тогтоомжоор болон эрх бүхий байгууллагаас тогтоосон нийтээр дагаж мөрдөх журмыг сахиулах зорилгоор явуулж буй цагдаагийн байгууллагын эргүүлийн үйл ажиллагаанд оролцох.

12.2.Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, гэмт хэргийг таслан зогсоох ажиллагаанд оролцох удирдамж, төлөвлөгөөг дотоодын цэргийн командлагч батална.

12.3.Энэ зүйлийн 12.1.1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэх үед дотоодын цэрэгт галт зэвсэг тавьж олгохыг хориглоно.

12.4.Дотоодын цэрэг энэ хуулийн 12.1.5-12.1.8-д заасан чиг үүргийг цагдаагийн байгууллагын хүч хэрэгсэл хүрэлцэхгүй тохиолдолд цагдаагийн байгууллагын хэрэгжүүлж байгаа үндсэн арга хэмжээнд дэмжлэг үзүүлэх замаар хэрэгжүүлнэ.

12.5.Дотоодын цэргийн алба хаагч энэ хуулийн 12.1.5-12.1.8-д заасан үүргийг гүйцэтгэх журмыг дотоод хэргийн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн тогтооно.

13 дугаар зүйл.Байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон, техникийн холбогдолтой осол, гал түймэр, хүн, малын гоц халдварт өвчин гарсан үед аврах ажил болон хорио цээрийн дэглэмийг сахиулахад оролцох

13.1.Дотоодын цэрэг байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон, техникийн холбогдолтой осол, гал түймэр, хүн, малын гоц халдварт өвчин гарсан үед аврах ажил болон хорио цээрийн дэглэмийг сахиулахад дараахь үүргийг гүйцэтгэнэ:

13.1.1.хүний амь нас, эрүүл мэндийг авран хамгаалах, яаралтай туламж үзүүлэх бүх талын арга хэмжээ авах;

13.1.2.байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул, техникийн холбогдолтой осол, гал түймэрийн хор уршигийг арилгахад туслалцаа үзүүлэх;

13.1.3.хянан харгалзах эзэнгүй үлдсэн иргэдийн болон, аж ахуйн нэгж, төрийн байгууллагын өмч хөрөнгийг хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх;

13.1.4.аврах ажиллагаа болон хорио цээрийн дэглэм тогтоосон бүс, түүний ойр орчимд нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах;

13.1.5.хүний амь нас, эрүүл мэнд, байгаль экологийн тэнцвэрт байдалд шууд хохирол учруулж болзошгүй эд зүйлийн хадгалалт, хамгаалалтад хяналт тавих, шаардлагатай тохиолдолд хамгаалалтад авах;

13.1.6.гэмт хэрэг, зөрчлийн ул мөр, нотлох баримтыг хадгалах, хамгаалах арга хэмжээ авах, гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийг саатуулах, цагдаагийн байгуулагад хүргэх;

13.1.7.тухайн нөхцөл байдалтай уялдуулан хуульд тусгайлан заасан эрх бүхий байгууллага, алба тушаалтнаас тогтоосон дүрэм, журам, шийдвэрийг биелүүлэх;

14 дүгээр зүйл.Объектыг түр хугацаагаар хамгаалах, зорчигч, ачаа тээшийг тээврийн замд харгалзан хүргэх

14.1.Дотоодын цэргийн командлагчийн шийдвэрээр их хэмжээний үнэт зүйл, мөнгөн тэмдэгт, цацраг идэвхит үүсгүүр, химийн хорт бодис эсхүл хүний амь нас, эрүүл мэнд, байгаль экологийн тэнцвэрт байдалд шууд хохирол учруулах эрсдэлтэй болон гэмт халдлагад өртөж болзошгүй бусад объектыг түр хугацаагаар хамгаалах, зорчигч, ачаа тээшийг тээврийн замд харгалзан хүргэнэ.

14.2.Дотоодын цэргийн командлагчийн шийдвэрээр энэ хуулийн 14.1-т заасан хамгаалалтыг гэрээгээр гүйцэтгэж болно.

14.3.Шаардлагатай тохиолдолд дотоодын цэрэг хууль тогтоомжид заасан үндэслэл журмын дагуу гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах шийдвэрийг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлнэ.

14.4.Хамгаалалтад авсан зорчигч, ачаа тээш аюулгүй газарт хүрсэн, бусад байгууллага, албан тушаалтны хамгаалалтад орсон, эсхүл учирч болзошгүй эрсдэл, аюул арилсан тохиолдолд түр хамгаалалтыг зогсооно.

14.5.Объектыг түр хугацаагаар хамгаалах, зорчигч, ачаа тээшийг тээврийн замд харгалзан хүргэх аюулгүй ажиллагааны журмыг дотоодын цэргийн штабын дарга шаардлагатай бол эрх бүхий албан тушаалтантай хамтран батална.

15 дугаар зүйл.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох

15.1.Дотоодын цэрэг нь цагдаагийн байгууллагатай хамтран террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны бүсийг хамгаалалтад авах, бүслэн хаах, тухайн бүсэд байгаа иргэдийн амь нас, эрүүл мэндийг авран хамгаалах, гэмт этгээдийг олж тогтоох, аюулгүй болгох, баривчлах үүргийг гүйцэтгэнэ.

16 дугаар зүйл.Дотоодын цэрэг дайн бүхий болон дайны байдал, онц байдлын үед ажиллах

16.1.Дотоодын цэрэг нь дайн бүхий болон дайны байдал, онц байдлын үед ажиллах журмыг дайн бүхий болон дайны байдлын тухай, онц байдлын тухай хууль тогтоомжоор тогтооно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ БИЕИЙН ХҮЧ, ТУСГАЙ ХЭРЭГСЭЛ, ГАЛТ ЗЭВСЭГ ХЭРЭГЛЭХ

17 дүгээр зүйл.Биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх нийтлэг үндэслэл

17.1.Дотоодын цэргийн алба хаагч хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх үедээ биеийн хүч, нэг бүрийн болон олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл, техник, галт зэвсэг хэрэглэж болно.

17.2.Дотоодын цэргийн алба хаагчийн хэрэглэх тусгай техник, хэрэгсэл, галт зэвсэг, сумны жагсаалт, бүртгэх, олгох, буцаан авах, хадгалах журмыг дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

17.3.Дотоодын цэргийн алба хаагчийг энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай биеийн хүч, тусгай техник, хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх бэлтгэл хангах журмыг дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

17.4.Дотоодын цэргийн алба хаагч албадлагын арга хэмжээг хэрэглэхдээ дараахь нийтлэг шаардлагыг баримтална:

17.1.1.зөвхөн хуульд заасан үндэслэл, журмын дагуу хэрэглэх;

17.1.2.нэн тэргүүнд хэрэглэхгүй байх;

17.1.3.тухайн нөхцөл байдалд тохируулан хэрэглэх, хамгийн бага хохирол учруулахыг эрмэлзэх.

17.5.Дотоодын цэргийн алба хаагч биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэх явцад хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан бол эмнэлгийн байгууллагад даруй мэдэгдэн, эрүүл мэндийн анхны тусламж үзүүлж, шууд захирах даргад мэдэгдэж, шууд захирах дарга нь прокурорт нэн даруй мэдэгдэнэ.

17.6.Дотоодын цэргийн алба хаагч шууд хэрэглэхээс бусад тохиолдолд биеийн хүч, тусгай хэрэгсэл хэрэглэхийн өмнө урьдчилан сануулж, дотоодын цэргийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэх хангалттай хугацаа олгоно.

17.7.Дотоодын цэргийн алба хаагч хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу галт зэвсэг, тусгай хэрэгсэл, биеийн хүч хэрэгслэснээс үүссэн үр дагаврын төлөө хариуцлага хүлээхгүй.

17.8.Энэ хуульд заасан чиг үүргээ гүйцэтгэж байгаагаас бусад тохиолдолд буюу анги, салбарын байрлал, эсхүл ангийн байрлалын гадна албан үүрэг, байлдааны жижүүрлэлт, харуул, хоногийн манааны үүрэг гүйцэтгэх зэрэг тохиолдолд дотоодын цэргийн алба хаагч галт зэвсэг, тусгай хэрэгслийг Зэвсэгт хүчний тухай хууль тогтоомж, цэргийн нийтлэг дүрмүүдэд заасан журмын дагуу хэрэглэнэ.

18 дугаар зүйл.Биеийн хүч хэрэглэх

18.1.Дотоодын цэргийн алба хаагч биеийн хүчийг дараахь тохиолдолд хэрэглэнэ:

18.1.1.дотоодын цэргийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, эсэргүүцсэн;

18.1.2.түр саатуулах болон цагдаагийн байгууллагад хүргэх үед эсэргүүцэл үзүүлсэн;

18.1.3.нэг бүрийн тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэх энэ хуульд заасан тохиолдолд.

18.2.Дотоодын цэргийн алба хаагчийн доор дурдснаас бусад тохиолдолд хүүхэд, жирэмсэн, хөгжлийн бэрхшээлтэй, бэртэл гэмтэлтэй болох нь илэрхий мэдэгдэж байгаа хүнд биеийн хүч хэрэглэхийг хориглоно:

18.2.1.өөрийнх нь, эсхүл бусад хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй байдлаар довтолсон;

18.2.2.тухайн хүн өөрийнхөө амь нас, эрүүл мэндийг хохироох үйлдэл хийж болзошгүй;

18.2.3.бусдын эд хөрөнгөд ноцтой хохирол учруулж болзошгүй.

Тайлбар: Энэ зүйлд заасан “биеийн хүч хэрэглэх” гэж дотоодын цэргийн алба хаагч өөрийн бие махбод, мэргэжлийн тусгай бэлтгэлийг ашиглан бусдын хөдөлгөөнийг хязгаарлах зорилгоор биеэр хийх үйлдлийг ойлгоно.

19 дүгээр зүйл.Тусгай хэрэгслийн төрөл

19.1.Дотоодын цэргийн байгууллага, алба хаагч дараахь тусгай хэрэгсэл хэрэглэнэ:

- 19.1.1.нэг бүрийн;
- 19.1.2.олон хүнд нөлөөлөх;
- 19.1.3.бусад.

19.2.Дотоодын цэргийн үйл ажиллагаанд нисдэг тэрэг, хуягт тээвэрлэгч, хамгаалалтын инженер-техникийн хэрэгсэл, газар уснаа явагч, тусгай хэрэгслээр тоноглогдсон бусад тээврийн хэрэгсэл, тээврийн хэрэгсэл албадан зогсоогч, галт хэрэглэл, гэрэл, дууны хэрэгсэл, тусгай будагч, тэмдэглэгч хэрэгсэл, албаны нохой болон бусад тусгай хэрэгсэл ашиглаж болно.

19.3.Дотоодын цэргийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэхдээ хамгаалах тусгай хэрэгслээр хангагдана.

20 дугаар зүйл.Нэг бүрийн тусгай хэрэгсэл

20.1.Нэг бүрийн тусгай хэрэгсэлд дараахь хэрэгсэл хамаарна:

- 20.1.1.гав;
- 20.1.2.бороохой;
- 20.1.3.цахилгаан гүйдлээр цохигч;
- 20.1.4.нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүр;
- 20.1.5.резинэн ба хуванцар сумтай буу;
- 20.1.6.нэг бүрийн бусад тусгай хэрэгсэл.

21 дүгээр зүйл.Нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх

21.1.Дотоодын цэргийн алба хаагчийн нэг бүрийн тусгай хэрэгслийг дараахь тохиолдолд хэрэглэнэ:

- 21.1.1.өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндэд учирч болзошгүй аюулыг таслан зогсоох;
- 21.1.2.гэмт хэрэг, зөрчлийн үйлдлийг таслан зогсоох, гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийг түр саатуулах;
- 21.1.3.зэвсэглэсэн болон зэвсэг хэрэглэн эсэргүүцэж болзошгүй хүнийг түр саатуулах;
- 21.1.4.түр саатуулагдсан хүнийг цагдаагийн байгууллагад албадан хүргэх, яллагдагч, ялтныг хуяглан хүргэх;

21.1.5.хяналтад байгаа хүн амиа хорлох, өөрийн бие махбодид гэмтэл учруулах, оргон зайлахаас урьдчилан сэргийлэх;

21.1.6.сэтгэцийн эмгэг, сэтгэл санаа хүчтэй цочрон давчидсаны улмаас өөрийгөө удирдах чадваргүй, түүнчлэн согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн, эсхүл догшин, хэрцгий авирлаж бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх;

21.1.7.хамгаалалтад байгаа объект, ачаа тээш, зорчигч, албаны байрыг эзлэн авсан, гудамж, замын хөдөлгөөн, хамгаалалтад байгаа объектыг бүслэн хаасныг чөлөөлөх;

21.1.8.хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор тавьсан дотоодын цэргийн алба хаагчийн шаардлагыг биелүүлээгүй;

21.1.9.нийтийн хэв журмыг бүлэглэн зөрчих, эсхүл нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, хууль бус жагсаал, цуглааныг албадан тараах, хамгаалалтад байгаа объект ачаа тээшийг хууль бус халдлагаас хамгаалах;

21.1.10.тээврийн хэрэгслийг зогсоох эрх бүхий албан тушаалтны шаардлагыг үл биелүүлэн зугтаасан;

21.1.11.энэ хуульд галт зэвсэг хэрэглэхээр заасан тохиолдолд.

21.2.Доор дурдсанаас бусад тохиолдолд жирэмсэн, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настай, гэмтэлтэй болох нь илэрхий мэдэгдэж байгаа хүнд нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэхийг хориглоно:

21.2.1.дотоодын цэргийн алба хаагч болон бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй байдлаар зэвсэглэн, эсхүл бүлэглэн довтолсон;

21.2.2.галт зэвсэг, хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болох зүйлээр зэвсэглэсэн хүн зэвсгээ хураалгах шаардлагыг үл биелүүлсэн, эсэргүүцсэн;

21.2.3.амиа хорлож болзошгүй.

21.3.Дотоодын цэргийн алба хаагч нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэх шийдвэрийг тухайн нөхцөл байдалд тохируулан бие даан гаргана.

22 дугаар зүйл.Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл

22.1.Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэлд дараахь хэрэгсэл хамаарна:

22.1.1.олон хүнд нөлөөлөх нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч;

22.1.2.усан хөөрөг;

22.1.3.утаан хөшиг үүсгэгч;

22.1.4.олон хүнд нөлөөлөх бусад тусгай хэрэгсэл.

23 дугаар зүйл.Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх

23.1.Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэх тухай шийдвэрийг дотоодын цэргийн анги, салбарын дарга, түүний эрх олгосноор тухайн ажиллагааг удирдаж байгаа албан тушаалтан гаргана.

23.2.Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг дараахь тохиолдолд хэрэглэнэ:

23.2.1.дотоодын цэргийн алба хаагч болон бусад хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болзошгүй байдлаар бүлэглэн довтолсон, эсэргүүцсэн;

23.2.2.хамгаалалтад байгаа объект, ачаа тээш, зорчигчид бүлэглэн халдсан, халдахыг завдсан;

23.2.3.хамгаалалтад байгаа объект, ачаа тээш, зорчигчийг булаан авсан, гудамж, замын хөдөлгөөн, хамгаалалтад байгаа объектыг бүслэн хаасныг чөлөөлөх;

23.2.4.хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж болох гэмт хэргийг бүлэглэн үйлдэж байгааг таслан зогсоох, баривчлах;

23.2.5.галт зэвсэг, хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болох бусад зүйлээр зэвсэглэсэн бүлэг зэвсгээ хураалгах шаардлагыг үл биелүүлэн эсэргүүцсэн;

23.2.6.нийтийн хэв журмыг бүлэглэн зөрчиж байгааг, эсхүл нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох, хүч хэрэглэсэн жагсаал цуглааныг албадан тараах;

23.2.7.гяндан, хорих анги, цагдан хорих байранд эмх замбараагүй байдал үүссэн.

23.3.Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг хэрэглэхийн өмнө дараахь арга хэмжээг авна:

23.3.1.боломжтой тохиолдолд прокурорт мэдэгдэх;

23.3.2.тусгай хэрэгсэл хэрэглэх тухай анхааруулж, тогтоосон бүсээс даруй гарахыг анхааруулах;

23.3.3.тухайн бүсэд байгаа хүнийг бүсээс гаргах талаар ухуулга хийх, хэрэглэх тусгай хэрэгслийн үйлчлэх нөлөөллийн талаар мэдээлэх;

23.3.4.яаралтай тусламж үзүүлэх мэргэжлийн байгууллагад тодорхой газар, байршилд ирэх тухай мэдэгдэх.

23.4.Энэ хуулийн 23.3-т заасан анхааруулга, ухуулгыг тусгай хэрэгслийн нөлөөлөлд өртөж болох хүмүүсийн дийлэнх хэсэгт хүргэх боломжтой бүх арга хэрэгслийг ашиглан зохион байгуулна.

23.5.Олон хүнд нөлөөлөх тусгай хэрэгслийг энэ хуулийн 23.3.2-т заасны дагуу анхааруулснаас хойш заасан хугацаанд үйлдлээ зогсоогоогүй, шаардлагыг биелүүлээгүй, эсхүл хүний амь нас, эрүүл мэнд хохирох эрсдэл бүхий нөхцөл байдал үүссэн бол шууд хэрэглэнэ.

23.6.Олон хүнд зэрэг нөлөөлөх тусгай хэрэгсэл хэрэглэсний дараа ажиллагааг гүйцэтгэсэн байгууллага нь холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран дараахь арга хэмжээг авна:

23.6.1.хордсон хүн, амьтан, тэсэрч дэлбэрэх, химийн болон аюултай хорт бодис алдагдах, гал түймэр гарах эх үүсвэр байгаа эсэхийг шалгаж, аюулгүй болгох;

23.6.2.эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх, шаардлагатай бусад үйлчилгээнд хамруулах;

23.6.3.орчныг ариутгах, цэвэршүүлэх арга хэмжээ авах талаар холбогдох байгууллагад мэдэгдэх;

23.6.4.тусгай хэрэгслийн үйлчлэл дуусах, эсхүл үүссэн аюултай нөхцөл арилах хүртэл тухайн орчинд эргүүл, хамгаалалт гаргаж, зөвлөгөө, сануулга өгөх.

24 дүгээр зүйл.Тээврийн хэрэгсэл албадан зогсоох тусгай хэрэгсэл хэрэглэх

24.1.Дотоодын цэргийн алба хаагч тээврийн хэрэгслийг албадан зогсоох тусгай хэрэгслийг дараахь тохиолдолд хэрэглэнэ:

24.1.1.өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндэд учирч болох бодит аюулыг таслан зогсоох шаардлага тулгарсан;

24.1.2.дотоодын цэргийн алба хаагчийн шаардлагыг үл биелүүлэн тээврийн хэрэгсэл ашиглан хамгаалалтад байгаа объектод нэвтэрсэн, эсхүл нэвтрэхийг завдсан;

24.1.3.тээврийн хэрэгслийг зогсоох талаар эрх бүхий албан тушаалтны тавьсан шаардлагыг үл биелүүлж зугтсан.

24.2.Тээврийн хэрэгслийг албадан зогсоох тусгай хэрэгслийг зорчих хөдөлгөөн ихтэй газар, олон нийтэд аюул учруулах эрсдэл байгаа үед хэрэглэхийг хориглоно.

25 дугаар зүйл.Хамгаалалтын инженер-техникийн хэрэгсэл ашиглах

25.1.Хүн хүчийг хэмнэх, объектын хамгаалалтын найдвартай байдлыг хангах, зөрчил гарч болзошгүй чиглэлд нягтралыг бий болгох зорилгоор хамгаалалтын инженер-техникийн хэрэгсэл ашиглана.

25.2.Хориотой бүс, мөр хянах зурвас, торон саад, хаалт, хашаа, гэрэлтүүлэг, инженерийн байгууламж, дохиоллын болон хяналтын хэрэгслүүд нь хамгаалалтын инженер-техникийн хэрэгсэлд хамаарна.

26 дугаар зүйл.Албаны нохой ашиглах

26.1.Дотоодын цэргийн алба хаагч хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор албаны нохой ашиглаж болно.

26.2.Дотоодын цэргийн алба хаагч өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндэд аюул учирч болзошгүй, зэвсэглэсэн этгээд зугтаасан, довтолсноос бусад тохиолдолд хүний эсрэг албаны нохой ашиглахыг хориглоно.

26.3.Албаны нохойг бэлтгэх, ашиглах, хамгаалах журмыг Цагдаагийн албаны тухай хуульд заасан журмын дагуу тогтооно.

27 дугаар зүйл.Галт зэвсэг хэрэглэх үндэслэл

27.1.Дотоодын цэргийн алба хаагч Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10.1-д зааснаас гадна дараахь тохиолдолд галт зэвсэг хэрэглэж болно:

27.1.1.хамгаалалтад байгаа объект, зорчиг, ачаа тээшинд бүлэглэн, эсхүл зэвсэглэн халдсан;

27.1.2.хулгайлагдсан, барьцаалагдсан хүн, ачаа тээш, эзлэгдсэн объектыг чөлөөлөх;

27.1.3.галт зэвсэг, хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болох бусад зүйлээр зэвсэглэсэн хүн зэвсгээ хураалгах шаардлагыг үл биелүүлэн эсэргүүцсэн;

27.1.4.хуяглан хүргэж яваа сэжиг бүхий этгээд, яллагдагч, шүүгдэгч, ялтанг суллахаар зэвсэглэн, эсхүл бүлэглэн довтолсон;

27.1.5.гяндан, хорих, цагдан хорих байранд эмх замбараагүй байдал үүсч хүний амь нас, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах нөхцөл байдал бий болсон;

27.1.6.террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох;

27.1.7.нийтийн эмх замбараагүй байдал үүссэн үед галт зэвсэг хэрэглэн довтолсон, хамгаалсан, хориглосон хүнд;

27.1.8.хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд хор уршиг учруулж болзошгүй болон учруулж байгаа амьтныг устгах;

27.1.9.зэвсэглэсэн болон зэвсэг хэрэглэн эсэргүүцэж болзошгүй хүнийг түр саатуулах.

27.2.Галт зэвсгийг түгшүүрийн дохио өгөх, тусламж дуудах, бэлтгэл, сургуулилтын болон хуульд заасан бусад тохиолдолд хэрэглэж болно.

27.3.Энэ хуулийн 28.2-т заасан түгшүүрийн дохио өгөх, тусламж дуудах, бэлтгэл, сургуулилтын үед галт зэвсэг хэрэглэх журмыг дотоодын цэргийн командлагч тогтооно.

28 дугаар зүйл.Галт зэвсэг хэрэглэх журам

28.1.Боломжтой бүх тохиолдолд галт зэвсэг хэрэглэхийн өмнө урьдчилан сануулна. Сануулга өгөх нь цаг алдаж хүний амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй бодит эрсдэл үүссэн нөхцөлд галт зэвсгийн шууд хэрэглэж болно.

28.2.Дотоодын цэргийн алба хаагч галт зэвсэг хэрэглэхтэй холбоотой дараахь арга хэмжээг шат дараатай авах үүрэг хүлээнэ:

28.2.1.энэ хуулийн 28.1-д заасан тохиолдол бий болсон үед галт зэвсгээ бэлэн байдалд авах;

28.2.2.тухайн хүнд галт зэвсэг хэрэглэх тухай сануулах, тодорхой зай байр тогтоох, хууль бус үйлдлээ зогсоохыг шаардах, эсхүл идэвхтэй үйлдэл хийхийг хориглох;

28.2.3.энэ хуулийн 29.2.2-т заасны дагуу сануулсны дараа тухайн хүн үйлдлээ үргэлжлүүлсэн тохиолдолд галт зэвсэг хэрэглэх;

28.3.Галт зэвсэг биедээ авч яваа дотоодын цэргийн алба хаагчийн саатуулсан этгээд дотоодын цэргийн алба хаагчийн галт зэвсгийг булаахаар довтолсон бол галт зэвсгийг шууд хэрэглэж болно.

28.4.Галт зэвсэг хэрэглэсний улмаас хүн гэмтсэн тохиолдолд эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлж, эрүүл мэндийн байгууллагад хүргэнэ. Хүний амь нас хохирсон тохиолдолд прокурор, эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэнэ.

28.5.Дотоодын цэргийн алба хаагч галт зэвсэг хэрэглэсэн үндэслэл, хүний биед учирсан гэмтэл, үзүүлсэн тусламж, эрүүл мэндийн байгууллагад мэдэгдсэн тухай шууд захирах даргадаа даруй танилцуулж, бичгээр тайлбар үйлдэх бөгөөд шууд захирах дарга нь прокурорт мэдэгдэнэ.

28.6.Дотоодын цэргийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэх үед энэ хуулийн 27.1-д заасан тохиолдол үүсэх үндэслэл тогтоогдвол галт зэвсэг хэрэглэж болзошгүй тухай сануулж болно.

28.7.Дотоодын цэргийн алба хаагч хуульд заасан үндэслэлээр галт зэвсэг хэрэглэж болзошгүй тухай сануулсныг галт зэвсэг хэрэглэсэнд тооцохгүй.

28.8.Галт зэвсэг хэрэглэсэн тухай илтгэх журмыг дотоодын цэргийн командлагч Улсын Ерөнхий прокурор хамтран батална.

29 дүгээр зүйл.Тусгай зориулалтын техник ашиглах

29.1.Дотоодын цэргийн алба хаагч дараахь тохиолдолд хуягт тээвэрлэгч, газар уснаа явагч, тусгай хэрэгслээр тоноглогдсон бусад тээврийн хэрэгсэл, тусгай зориулалтын техник ашиглана:

29.1.1.террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох;

29.1.2.барьцаалагдсан хүн, булаан эзлэгдсэн байнгын болон түр хугацаагаар хамгаалалтад байгаа объект, зорчигч, ачаа тээшийг чөлөөлөх;

29.1.3.байнгын болон түр хугацаагаар хамгаалалтад байгаа объект, зорчигч, ачаа тээш, өөрийн байрлаж байгаа объектод зэвсэглэн эсхүл бүлэглэн довтолсныг няцаах;

29.1.4.хууль бус зэвсэгт бүлэглэлийн үйл ажиллагааг таслан зогсоох;

29.1.5.хууль бус үйлдлээ таслан зогсоох, зэвсэгээ хураалгах тухай хууль ёсны шаардлагыг биелүүлэхээс татгалзан зэвсэглэн эсэргүүцэл үзүүлж буй этгээдийн эсэргүүцлийг дарах;

29.1.6.нийтийг хамарсан эмх замбраагүй байдал болон онц байдлын үед бусдын амь нас, эд хөрөнгө, аюулгүй байдлыг хамгаалах;

29.2.Галт зэвсэг, тусгай зориулалтын техник ашиглах тухай шийдвэрийг тухайн ажиллагааг удирдагч дотоодын цэргийн командлагчийн зөвшөөрснөөр гаргана.

ТАВДУГААР БҮЛЭГ ДОТООДЫН ЦЭРГИЙН АЛБА ХААГЧ, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН БАТАЛГАА

30 дугаар зүйл.Дотоодын цэргийн алба хаагч

30.1.Монгол Улсын цэргийн тангарагийг өргөж, дотоодын цэргийн аль нэг анги, салбарт офицерын, ахлагчийн, хугацаат болон гэрээт цэргийн алба хааж байгаа, цэргийн цолтой иргэнийг дотоодын цэргийн алба хаагч гэнэ.

30.2.Дотоодын цэрэгт шаардлагатай мэргэжлийн алба хаагч бэлтгэх зорилгоор цэргийн сургууль, гадаад, дотоодын бусад сургалтын байгууллагад дотоодын цэргийн алба хаагчийг гэрээний үндсэн дээр суралцуулж болно.

31 дүгээр зүйл.Дотоодын цэргийн алба хаагчид тавигдах шалгуур

31.1.Дотоодын цэргийн алба хаагчид тавигдах шалгуур үзүүлэлтийг Цэргийн албаны тухай хуульд заасны дагуу тогтооно.

31.2.Гүйцэтгэх чиг үүргийн онцлогтой уялдуулан дотоодын цэргийн алба хаагчид тавигдах тусгайлсан шалгуур үзүүлэлтийг дотоодын цэргийн командлагч цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллагатай зөвшилцөн тогтоож болно.

31.3.Дотоодын цэргийн алба хаагч Цэргийн албаны тухай хууль, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль болон Зэвсэгт хүчний тухай хуульд заасны дагуу цэргийн боловсрол эзэмших, сургалт, бэлтгэлийн арга хэмжээнд хамрагдах бөгөөд энэ хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн мэдлэг олгох, галт зэвсэг, тусгай техник, хэрэгсэл хэрэглэх бэлтгэл, сургалтад заавал хамрагдсан байна.

32 дугаар зүйл.Дотоодын цэргийн алба хаагчийн эрх

32.1.Дотоодын цэргийн алба хаагч Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан нийтлэг эрхээс гадна энэ хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхдээ дараахь эрх эдэлнэ:

32.1.1.объектыг хамгаалах, хорио цээрийн дэглэмийг сахиулахад оролцохдоо хамгаалалтад байгаа объект, бүсэд нэвтрэн орох болон хууль бусаар нэвтрэхээр завдсан хүний бичиг баримтыг шалгах, түүний бие, эд зүйл, тээврийн хэрэгсэл, ачаа тээшинд үзлэг хийх;

32.1.2.энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ иргэдэд шаардлага тавих, биелэлтийг хангуулах, зөрчлийг таслан зогсоох, гэмт хэрэг, зөрчил үйлдсэн этгээдийг түр саатуулж цагдаагийн байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх;

32.1.3.хамгаалж байгаа объектод халдсан, хууль бусаар нэвтрэн орохыг завдсан этгээдийг мөрдөн хөөх, түр саатуулах, цагдаагийн байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх.

32.1.4.хамгаалж байгаа объект болон чиг үүргийн хүрээнд дэмжлэг үзүүлж буй ажиллагааны үед шаардлагатай мэдээлэл авах, хамгаалалтыг сайжруулахтай холбогдсон саналыг объектын захиргаа болон холбогдох байгууллагад тавих;

32.1.5.хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор хамгаалалтад байгаа объектод өдөр шөнийн аль ч цагт чөлөөтэй нэвтрэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хамгаалалтын бүс дэх сэжиг бүхий эд зүйлд үзлэг хийх;

32.1.6.нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын даргын шийдвэрээр хамгаалалтад байгаа объектод хууль бусаар нэвтэрсэн этгээдийг олж тогтоох, халдлага, гэнэтийн аюул ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор хамгаалалтад байгаа объектын ойр орчим газрыг бүслэн хаах, уг бүсэд байгаа иргэдийн бичиг баримтыг шалгах, эд зүйлд үзлэг хийх;

32.1.7.хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ иргэд, аж ахуйн нэгж, байгууллага хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх захиргааны хэм хэмжээний актаар тогтоосон дүрэм, журмыг биелүүлэх, хууль бус үйлдлээ таслан зогсоохыг шаардах;

32.1.8.гэмт хэрэг, зөрчлийн эд мөрийн баримт болох эд зүйлийг хуульд заасны дагуу түр хураан авах, эрх бүхий байгууллага, албан тушаалтанд хүлээлгэн өгөх;

32.1.9.гэмт хэрэг, зөрчил үйлдэгдсэн, эсхүл аюул учирч болзошгүй тохиолдолд хамгаалалтад байгаа объектод хүн, тээврийн хэрэгсэл нэвтрүүлэхийг хязгаарлах;

32.1.10.энэ хуулийн 10.1.2-д заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Цагдаагийн албаны тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүний бичиг баримтыг шалгах;

32.1.11.хамгаалалтад байгаа объектын ойр орчимд илэрсэн сэжиг бүхий хүн, тээврийн хэрэгслийг бичиг баримтыг шалгах, илэрсэн зөрчлийг цагдаагийн байгууллагад шалгуулахаар шилжүүлэх;

32.1.11.хуульд заасан бусад.

32.2.Дотоодын цэргийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэх үедээ хүнийг 6 цаг хүртэлх хугацаанд түр саатуулж болох бөгөөд хүнийг түр саатуулах_зааврыг дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Улсын ерөнхий прокурортой хамтран батална.

33 дугаар зүйл.Дотоодын цэргийн алба хаагчийн үүрэг

33.1.Дотоодын цэргийн алба хаагч Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан нийтлэг үүргийг хүлээнэ.

33.2.Дотоодын цэргийн алба хаагч гэмт хэрэг, зөрчилд холбогдон шалгагдаж байгаа бол энэ тухайгаа шууд захирагдах албан тушаалтанд мэдэгдэх үүрэгтэй.

33.3.Хуульд зааснаас бусад тохиолдолд дотоодын цэргийн алба хаагч хувь хүн, байгууллагын нууцтай холбоотой мэдээллийг хайх, цуглуулах, хэрэглэх, тараахыг хориглоно.

33.4.Дотоодын цэргийн байгууллага, алба хаагч албан үүргээ гүйцэтгэхдээ хуульд заасан үндэслэл, журмын дагуу биеийн хүч, тусгай хэрэгсэл, галт зэвсэг хэрэглэнэ.

34 дүгээр зүйл.Дотоодын цэргийн алба хаагчийн эрхийн хязгаарлалт

34.1.Дотоод цэргийн алба хаагчид Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан хязгаарлалт нэгэн адил үйлчилнэ.

35 дугаар зүйл.Дотоодын цэргийн алба хаагчийн чиг үүргээ хэрэгжүүлэх баталгаа

35.1.Энэ хуулийн 10.1-д заасан чиг үүргийг хэрэгжүүлж байгаа дотоодын цэргийн алба хаагчид Цагдаагийн албаны тухай хуулиар цагдаагийн алба хаагчдад олгосон баталгаа нэгэн адил үйлчилнэ.

35.2.Дотоодын цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлыг энэ_хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд Цэргийн албаны тухай хууль, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль тогтоомж, цэргийн нийтлэг дүрмээр зохицуулна.

35.3.Дотоод цэргийн алба хаагч Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу тэтгэвэр тогтоолгож, тэтгэмж авна.

35.4.Дотоодын цэргийн алба хаагчдын ажилласан хугацааг тооцоход улсын онц чухал объектын харуул хамгаалалтад ажилласан 1 жилийг 1 жил 2 сараар тооцно.

35.5.Хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлж буй дотоодын цэргийн алба хаагчийн хууль ёсны шаардлагыг иргэд, аж ахуйн нэгж, байгууллага биелүүлэх үүрэгтэй.

35.6.Дотоодын цэргийн хамгаалалтад байгаа объектын захиргаа дотоодын цэргийн алба хаагчийг чиг үүргээ хэвийн хэрэгжүүлэх нөхцөлөөр хангах үүрэгтэй.

35.7.Дотоодын цэргийн алба хаагч дүрэмт хувцастайгаар албан үүргээ гүйцэтгэх үедээ хот суурингийн доторх нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр үнэ төлбөргүй зорчино.

36 дугаар зүйл.Дотоодын цэргийн алба хаагчийн дүрэмт хувцас, цол

36.1.Дотоодын цэргийн алба хаагчид Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар батлагдсан дүрэмт хувцас, цэргийн цол хэрэглэнэ. Хуульд зааснаас бусад тохиолдолд Дотоодын цэргийн дүрэмт хувцастай ижил загварын дүрэмт болон ажлын хувцас өөр байгууллагад хэрэглэхийг хориглоно.

36.2.Цэргийн цолыг хэрэглэх, олгох, бууруулах, хураан авах, сэргээх харилцааг Цэргийн албаны тухай хуулийн 6 дугаар бүлэгт заасан журмын дагуу зохицуулна.

37 дугаар зүйл.Дотоодын цэргийн санхүүжилт, материал техникийн хангамж, зэвсэглэл

37.1.Дотоодын цэрэг нь улсын төсвөөс санхүүжнэ.

37.2.Дотоодын цэргийн аж ахуй, материал-техникийн хангалтыг цагдаагийн төв байгууллага хариуцна.

37.3.Дотоодын цэргийн байлдааны зориулалттай зэвсэглэл, техникийн хангалт нь Батлан хамгаалах тухай хууль тогтоомжийн дагуу улсын батлан хамгаалах төсөвт тусгагдаж захиалгын дагуу хангагдана.

37.4.Энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай зэвсэг, тусгай хэрэгслийг цагдаагийн төв байгууллагаас хангана.

38 дугаар зүйл.Дотоодын цэргийн алба хаагчдад хүлээлгэх хариуцлага

38.1.Монгол Улсын хууль тогтоомж, өргөсөн тангараг, цэргийн дүрмийн заалтыг зөрчсөн дотоодын цэргийн алба хаагчид хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

39 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

39.1.Энэ хуулийг Цагдаагийн албаны тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн албаны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэг, мөн зүйлийн 28.6.3 дахь заалтын “хилийн” гэсний дараа “ба дотоодын” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Дотоодын цэргийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “бол” гэсний дараа “дотоодын цэрэг болон” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Дотоодын цэргийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай 9 дэх заалт нэмсүгэй:

“9/дотоодын цэргийн жинхэнэ албаны генерал, офицер, ахлагч, түрүүч, байлдагч;”

2 дугаар зүйл.Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 1 дүгээр зүйл, 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “хилийн” гэсний дараа “болон дотоодын” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Дотоодын цэргийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭНХИЙГ ДЭМЖИХ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг, 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтын “хилийн” гэсний дараа “ба дотоодын” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Дотоодын цэргийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ОНЦ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Онц байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалтын “цагдаа,” гэсний дараа “дотоодын цэрэг,” гэж, 3 дахь хэсгийн “цагдаа,” гэсний дараа “дотоодын цэрэг,” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл.Онц байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “цагдаагийн байгууллагын” гэснийг “цагдаа, дотоодын цэргийн” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “цагдаагийн байгууллагад” гэснийг “цагдаа, дотоодын цэрэгт” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Дотоодын цэргийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН
АШИГЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн “цагдаагийн байгууллага” гэснийг “дотоодын цэрэг” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Дотоодын цэргийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТЕРРОРИЗМТОЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Терроризмтой тэмцэх тухай хуулийн 10 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай 10.1.3 дахь заалт нэмсүгэй.

“10.1.3.дотоод цэргийн томилогдсон салбар, нэгж.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Дотоодын цэргийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ БА МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсгийн “хилийн” гэсний дараа “болон дотоодын” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Дотоодын цэргийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨРИЙН НУУЦЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Төрийн нууцын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 3 дахь хэсгийн “цагдаа,” гэсний дараа “дотоодын цэрэг,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Төрийн нууцын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 3 дахь заалтын “цагдаагийн байгууллагын” гэснийг “цагдаа, дотоодын цэргийн байгууллагын” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Дотоодын цэргийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4.4 дэх заалтын “цагдаа,” гэсний дараа “дотоодын цэрэг,” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Дотоодын цэргийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтын “хилийн” гэсний дараа “ба дотоодын” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Дотоодын цэргийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЧӨЛӨӨТ БҮСИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Чөлөөт бүсийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийн “цагдаагийн байгууллага” гэснийг “дотоодын цэрэг гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Дотоодын цэргийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын “цагдаа” гэсний дараа “, дотоодын цэрэг” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Дотоодын цэргийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2016 оны дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**“Монгол Улсын төрөөс орон нутгийн хамгаалалтын
талаар баримтлах бодлого батлах тухай” тогтоолын
хавсралтад өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын их Хурлаас ТОГТООХ НЬ:

1. “Монгол Улсын төрөөс орон нутгийн хамгаалалтын талаар баримтлах бодлого батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2006 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 98 дугаар тогтоолын хавсралтын 4.2.5 дахь заалтын “хилийн” гэсний дараа “болон дотоодын” гэж нэмсүгэй.

2. Энэ тогтоолыг Дотоодын цэргийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2016 оны ... дугаар
сарын-ны өдөр

Улаанбаатар
хот

**ДОТООДЫН ЦЭРГИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ
ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Улсын Их Хурлын 2014 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр баталсан Цагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд заасны дагуу цагдаа, хилийн хамгаалах байгууллагад шилжүүлсэн дотоодын цэргийн бие бүрэлдэхүүн, хугацаат цэргийн алба хаах үйл ажиллагаатай холбоотой төсөв, дэд бүтэц, барилга байгууламж, материал техникийн хангамж, зэвсэг хэрэгслийг буцаан Дотоодын цэрэгт шилжүүлэх ажлыг 2017 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

2 дугаар зүйл. Цагдаагийн алба хаагч дотоодын цэрэгт шилжсэн үеэс Дотоодын цэргийн тухай хуульд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ. Алба хаагчдыг цэргийн мэргэжлийн сургалтад хамруулж, хувцас, агсамжаар хангах ажлыг цагдаагийн төв байгууллага /Дотоодын цэргийн штаб/ хариуцан гүйцэтгэнэ.

3 дугаар зүйл. Энэ хуулийн 2-т зааснаар дотоодын цэрэгт шилжсэн алба хаагчийг цэргийн мэргэжлийн сургалтад хамруулж, хувцас, агсамжаар хангах хүртэл хугацаанд одоо хэрэглэж буй цагдаагийн дүрэмт хувцасны мөрдөс, цол, бэлэгдлийг хэрэглүүлнэ.

4 дүгээр зүйл. Дотоодын цэргийн тухай хуулийн 14.2-т заасан гэрээгээр гүйцэтгэх хамгаалалтын хугацааг Дотоодын цэргийн дарга тогтоож, төлбөрийн хэмжээг санхүүгийн болон дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

5 дугаар зүйл. Дотоодын цэргийн тухай хуулийн 35.4-т заасан хугацаа нь энэ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс өмнө цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон иргэнд хамаарахгүй.

6 дугаар зүйл. Энэ хуулийг Дотоодын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг